



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/32

Эрдэнэт

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" 166 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2."Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 14 хоног тутам (Засаг даргын зөвлөл)-д танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (С.Баянмөнх)-т үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Амгаланбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАТ-ЭРДЭНЭ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын  
Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны  
өдрийн А/32 дугаар захирамжийн хавсралт



**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч: С.Баянмөнх (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Болормаа (Улсын бүртгэгч)

Г.Ганхөлөг (Газрын даамал)

Г.Батбаатар (Хаан банкны эдийн засагч)

Э.Батчимэг (Төрийн банкны эдийн засагч)

Т.Болдбаатар (Сангийн далай багийн Засаг дарга)

Г.Билэгдэмбэрэл (Баяннуур багийн Засаг дарга)

Х.Даш-Очир (Баянзүрх багийн Засаг дарга)

Б.Одхүү (Нүхт багийн Засаг дарга)

Г.Баасанцэрэн (Хэсгийн төлөөлөгч)

Нарийн бичгийн дарга: Ц.Наранбямба (Хүнс жижиг дунд үйлдвэрлэл,  
хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

---oOo---